

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ, ЗАСГИЙН ГАЗРЫН  
БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

***Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага***

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр бүрдсэн Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр товлон зарлан хуралдуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулж, Улсын Их Хурлын анхдугаар чуулганы 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаас Монгол Улсын Ерөнхий сайдыг томилсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ." гэж заасны дагуу шинээр томилогдсон Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг боловсруулна.

Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүний хувьд 2020-2024 онд 16 яам, 21 сайдтай ажилласан бол шинэ Засгийн газрыг 16 яам, 22 сайдтай байхаар тооцож байна.

***Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ***

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэж заасныг үндэслэн Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын ээлжит сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын дараах бүтэц, бүрэлдэхүүнийг танилцуулж байна:

-Засгийн газрын бүтэц:

- 1/Эдийн засаг, хөгжлийн яам;
- 2/Гадаад харилцааны яам;
- 3/Сангийн яам;
- 4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам;
  
- 5/Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;
- 6/ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам;

- 7/Батлан хамгаалах яам;
- 8/Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам;
- 9/Боловсролын яам;
- 10/Гэр бүл, хүний хөгжлийн яам;
- 11/Зам, тээврийн хөгжлийн яам;
- 12/Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
- 13/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 14/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам;
- 15/Эрчим хүчний яам;
- 16/Эрүүл мэндийн яам.

-Засгийн газрын бүрэлдэхүүн:

1. Монгол Улсын Ерөнхий сайд
2. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
3. Монгол Улсын Шадар сайд /онцгой байдлын асуудал эрхэлсэн/;
4. Монгол Улсын Шадар сайд /өрсөлдөөний асуудал эрхэлсэн/;
5. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
6. Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга;
7. Монгол Улсын сайд, 20 минутын хот-Үндэсний хорооны дарга;
8. Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга;
9. Гадаад харилцааны сайд;
10. Сангийн сайд;
11. Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайд;
12. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд;
13. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
14. Батлан хамгаалахын сайд;
15. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
16. Боловсролын сайд;
17. Гэр бүл, хүний хөгжлийн сайд;
18. Зам, тээврийн хөгжлийн сайд;
19. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
20. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
21. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
22. Эрчим хүчний сайд;
23. Эрүүл мэндийн сайд.

***Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал***

Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүнээ шинэчлэн тогтоосноор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээс гадна Улсын Их Хурлын ээлжит сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг ханган эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжинэ.

Улаанбаатар хот-20 минутын хот бодлогыг хэрэгжүүлж, иргэд нийгмийн үйлчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.

Төр нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байж, төрийн оролцоог багасгаж, хөрөнгө оруулалтыг дэмжиж, хувийн хэвшлийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухаанд суурилан төрийн үйлчилгээг хялбаршуулж, төрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгана.

Хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

***Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал***

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээг тогтоох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төсөл, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.